



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/497

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3/а/, 29,2, Засгийн газрын 2017 оны 186 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит IV хуралдааны II тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймаг, сумдын аюулгүй нөөцөд 360 тн өвс, 130 тн тэжээл худалдан авахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Аймаг, сумдын аюулгүй нөөцийн өвс, тэжээл худалдан авахад шаардагдах 155000000 /Нэг зуун тавин таван сая/ төгрөгийг Эрдэнэт сангаас эргэн төвлөрүүлэх нөхцөлтэйгээр гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Аюулгүйн нөөцийн өвс, тэжээл худалдан авалтыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, татан авалтыг цаг алдалгүй хийж гүйцэтгүүлэн, дүнг 2017 оны 10 дугаар сарын 01-ний дотор танилцуулж, гарсан зардлыг 2018 оны 03 дугаар сарын 30-ны дотор Эрдэнэт санд эргэн төвлөрүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/, Баян-Өндөр сумын Засаг дарга С.Ганцогт, Жаргалант сумын Засаг дарга Б.Зоригтбаяр нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /н.Батжаргал/, Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын  
31 өдрийн А/З.97 дугаар захирамжийн хавсралт

АЙМАГ, СУМДЫН АЮУЛГҮЙ НӨӨЦИЙН ӨВС, ТЭЖЭЭЛ  
ХУДАЛДАН АВАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

1.Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээл худалдан авах тооцоо

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг /тн/	Ширхэг	Нэг бүрийн үнэ зах зээийн ханш /төг/	Нийт дүн /төг/
1	Өвс	тн	60	3000	6,500	19500000
2	Хивэг	тн	30	1200	15,000	18000000
<b>Дүн</b>						<b>37500000</b>

2.Баян-Өндөр сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээл худалдан авах тооцоо

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг /тн/	Ширхэг	Нэг бүрийн үнэ зах зээийн ханш /төг/	Нийт дүн /төг/
1	Өвс	тн	150	7500	6,500	48750000
2	Хивэг	тн	50	2000	15,000	30000000
<b>Дүн</b>						<b>78750000</b>
Төсөвлөсөн /бэлэн байгаа/						40000000
<b>Эрдэнэт сангаас зээлэх хөрөнгийн дүн</b>						<b>38750000</b>

3.Жаргалант сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээл худалдан авах тооцоо

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг /тн/	Ширхэг	Нэг бүрийн үнэ зах зээийн ханш /төг/	Нийт дүн /төг/
1	Өвс	тн	150	7500	6,500	48750000
2	Хивэг	тн	50	2000	15,000	30000000
<b>Дүн</b>						<b>78750000</b>

АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ӨВС, ТЭЖЭЭЛ ХУДАЛДАН  
АВАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Нөөц бүрдүүлэх газар	Өвс	Хивэг	Эрдэнэт сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр авах хөрөнгийн хэмжээ /төгрөг/
1	Аймгийн аюулгүйн нөөц	60 тн	30 тн	3750,000
2	Баян-Өндөр сум	150 тн	50 тн	38750000
3	Жаргалант сум	150 тн	50 тн	78750000
<b>Дүн</b>		<b>360 тн</b>	<b>130 тн</b>	<b>155000000</b>